# ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭР ХӨВСГӨЛИЙН БЦГ-ЫН АРДАГИЙН АМ НЭРТЭЙ ГАЗАРТ БАЙРЛАХ “МАРГАД” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР РА97012017/

Хянасан:
БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн П.Шинэцэцэг

Биелэлтийг тайлагнасан:
“Маргад” жуулчны баазын захирал П.Эрхэмбаяр

“Маргад” жуулчны баазын менежер Б.Даваахүү

2023 он

**Аялал жуулчлал, үйлчилгээний төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга**

1. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

6.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дүгнэлт, санал:

Тайлангийн хавсралтууд:

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг /цэг бүр дээр 2-оос доошгүй/
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг /арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг /нэгж талбай бүр дээр хийхээс өмнө, хийж байх үеийн, хийсний дараах байдлыг харуулсан гэрэл зургууд хавсаргах/
- Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ, түүний биелэлтийг нотлох баримтууд, гэрэл зургууд
- Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг барьж байгуулсан далд ажлын акт
- Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг хүлээж авсан актын хуулбар

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| Төслийн нэр: | “Маргад” аялал жуулчлалын бааз |
| Төсөл хэрэгжүүлэгч: | П. Эрхэмбаяр |
| Регистрийн дугаар: | РА 97012017 |
| Хаяг, байршил: | Хөвсгөл, Алагэрдэнэ сум Хатгал тосгон , 6-р баг |
| Захирал: | П. Эрхэмбаяр |
| Утас: | 99383080,88013740 |

*Хүснэгт 1 Төслийн байршил*

| № | Хойд өргөрөг | Зүүн уртраг | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|
| **1** | 50 37 39.98 | 100 11 48.15 | 8816 $м^2$ |
| **2** | 50 37 38.82 | 100 11 43.05 | |
| **3** | 50 37 40.67 | 100 11 41.36 | |
| **4** | 50 37 42.68 | 100 11 47.22 | |

Дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт жил бүр оролцон, жилээс жилд өөрийн гадаад харилцаагаа өргөжүүлсээр ирсэн. 2015 оноос гэр буудал, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн туршлагатай
Экологи, газар зүйн хувьд онцгой ач холбогдолтой байгалийн аялал жуулчлалын томоохон бүс болох Хөвсгөлийн БЦГ-ыг түшиглэн гадаад, дотоодын аялагч жуулчдын амрах таатай орчинг бүрдүүлэн, экосистемийг сурталчилан таниулж, үндэсний болон олон улсын түвшинд нийцсэн, нийгэм эдийн засгийн хувьд үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ тогтвортой аялал жуулчлалын нэг хэлбэр болох Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Аялал Жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахаар зорьж байна.

Манай Маргад жуулчны бааз нь Дотоод гадаадын амрагч нарыг таатай орчинг бүрдүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл цэвэр орчинд үйлчилж. нэг ээлжиндээ 60-70 жуулчин хүлээн авах хүчин чадалтай, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг. Жуулчны баазын талбайд нийт ресторан – 1, амрагчдын байр – 9, Монгол гэр – 9 болон бусад тохижилтын барилга байгууламж байна. Үүнд: ариун цэврийн байгууламж, саравч, хүүхдийн тоглоомын талбай, гар бөмбөг, сагсан бөмбөг, агаарын теннис, ширээний теннис зэрэг байдаг.

“Маргад” жуулчны бааз нь Засаг захиргааны хувьд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Vl багийн нутаг дэвсгэр, Хөвсгөлийн БЦГын Жанхайн ардагын ам нэртэй газарт, Хөвсгөл нуурын баруун эрэгт байрладаг.









## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Иргэн П. Эрхэмбаярын “Маргад” аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг матрицийн аргыг ашиглан тодорхойлов.

| **Нөлөөлөлд өрттөгч** / **Нөлөөлөгч** | **Газрын гадарга, хэвлий** | | **Агаарын чанар** | | **Хөрсөн бүрхэвч** | | **Ургамлан нөмрөг** | | **Амьтны аймаг** | | **Газрын доорхи ус** | | **Хүн амын эрүүл мэнд** | | **Дүн** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хатуу хог хаягдал** | 3 | 3 | 5 | 6 | 7 | 6 | 7 | 6 | 4 | 3 | 4 | 5 | 7 | 5 | **37** | **34** |
| **Шингэн хог хаягдал** | 3 | 3 | 5 | 6 | 7 | 6 | 7 | 6 | 4 | 3 | 6 | 6 | 7 | 5 | **39** | **35** |
| **Дуу чимээ, шуугиан** | 1 | 1 | 5 | 6 | 1 | 1 | 1 | 1 | 5 | 5 | 1 | 1 | 7 | 8 | **21** | **23** |
| **Тээврийн хэрэгсэл (утаа, тоосжилт)** | 5 | 5 | 6 | 6 | 5 | 4 | 5 | 4 | 4 | 3 | 2 | 1 | 5 | 6 | **32** | **29** |
| **Дэд бүтэц /авто зам, шугам хоолой, хашаа, тоглоомын талбай г.м/** | 2 | 3 | 6 | 7 | 5 | 6 | 5 | 6 | 4 | 5 | 1 | 1 | 6 | 7 | **29** | **35** |
| **Барилга байгууламж /төслийн төлөвлөлт/** | 4 | 5 | 4 | 3 | 5 | 6 | 5 | 6 | 4 | 3 | 1 | 1 | 4 | 3 | **27** | **27** |
| **Дүн** | **18** | **20** | **31** | **34** | **30** | **29** | **30** | **29** | **25** | **22** | **15** | **15** | **36** | **34** | **185** | **183** |

Жуулчны баазын үйл ажиллагааны явцад орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах бичиг баримт зэргийг байгалийн бүрэлдэхүүн тус бүрээр тодорхойлон доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлсэн болно.

### Хүснэгт 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг | 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 7 | 8 | 9 | |
| 1. | Жуулчны бааз ашиглалтын явцад машин механизмууд ын түлшний шаталтаас | Жуулчны баазын үйл ажиллагаан аас гарах тоосжилтыг бууруулах, | Төслийн талбайн зогсоол болон үүд хэсгийн | Жилд3 9 удаа*304 0.8төг=91 22төг | 2 сард 6 удаа | Агаарын тухай хууль, - MNS 4585:200 7 | Баазын машины зогсоол орох. гарах хаалганы үүд, баазын туушаа төв замын хэсгийг 6 сард 1 удаа,7 сард 3 удаа,8 сард 2 нийт 6 удаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд төслийн талбай орчмын шороон замаас тоосжилт үүсэх дуу чимээ, хог хаягдал зэрэг болно | явган зам авто машины зогсоолын тоосжилтыг багасгах зорилгоор усалгаа хийх. | 1500 м2 талбай | 9122төг*1 жил= 9122төг | | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Монгол Улсын агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005; - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010 | 19,8м3 буюу 15840л усаар услаж 11919 төгрөг зарцуулж тоосжилтыг багасгаж усалгаа хийсэн. |
| 2. | Жуулчны баазын үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх | Жуулчны баазаас гарсан хог хаягдлыг ангилан ялгаж Хатгалын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэж хүргэх. | Төслөөс гарч буй хатуу бүх төрлийн хог хаягдал | 450,000 | 2 сард 3 удаа | | Хатуу хог хаягдлыг жуулчны баазын талбайд хог хаягдал түр хадгалах цэгт хуримтлуулан “Хүн байгаль” нөхөрлөлтэй Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хамтран ажиллах гэрээг байгуулж Хатгал тосгоны хогийн нэгтсэн цэгт зайлуулж байна. Үйл ажиллагааны явцад нийт 3 удаа хог тээвэрлэж, 450 000 мян.төг зарцуулсан. Хатуу хогийг ангилан ялгах, шингэн хаягдлыг ачиж, зайлуулах ажлыг нэг хүнд хариуцуулсан |
| 3. | | Жуулчны баазаас гарах бохирыг Хатгал тосгоны Харганы амын цэвэрлэх байгууламж руу зөөвөрлөх | Шингэн хог хаягдал | 1.050.000 | 2 сард 3 удаа | | Жуулчны баазын үйл ажиллагаанаас гарах бохир усыг бохирын цооногт түр хуримтлуулан Мөнх-оргил транс ХХК-тай гэрээ байгуулж үйл ажиллагааны явцад 3 удаагийн тээвэрлэлтээр 12 тн бохир усыг Харган амны цэвэрлэх байгууламжид тээвэрлүүлсэн үүнд 720.000 төгрөг зарцуулсан болно. |
| 4. | Нийт дүн | 1,181,919/мян.төг/ | | | | | |

## ГУРАВ. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

**Хүснэгт 3.1. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг | 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 7 | 8 | 9 | |
| 1. | Төслийн талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламж бий болгох | Жуулчны баазын баруун хойд талд ногоон зурвас бий болгох | Мод тарих, зүлэгжүүлэх /Шар хуайс, нарс/ Олон настын үр цацаж ногоон байгууламж бий болгох | 1730000 | 5-6 саруудад | -Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008<br>- “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008<br>- Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011 | Шар хуайс 20ш, Шинэс 20ш, улиас 20ш нийт 60 мод тарьсан Ерхөг согоовор олон наст ургамлын 5кг үрээр хүн их явдаг талбайд тарилт хийж зүлэгжүүлсэн үүнд 830.000 төгрөгийг зарцуулсан. |
| | Нийт | 830.000 /мян.төг/ | | | | | |

## ДӨРӨВ. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 4.1 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг | 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 7 | 8 | 9 | |
| 1. | Ахуйн | Хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн | Хог хаягдал тээвэрлэдэг зориулалтын авто машины жолоочтой гэрээ байгуулж тээвэрлүүлэх. | 750.000 | 2 сард 5 удаа | Хог хаягдлын тухай хууль, 2017 он | Хатуу хог хаягдлыг жуулчны баазын талбайд хог хаягдал түр хадгалах цэгт хуримтлуулан Хүн - байгаль нөхөрлөлийн ахлагч Ж.Сайнбаяртай “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ” байгуулсаний дагуу |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | | хэрэгслээр тээвэрлэх | | | | | Хатгал тосгоны нэгдсэн хогийн цэгт зайлуулж байна.Үйл ажиллагааны явцад нийт 3 удаа хог тээвэрлүүлж, 450 000 мян.төг зарцуулсан |
| 2. | Үйлдвэрийн | Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн сав ашиглах | Жуулчны баазын салхины доод хэсэгт хог хаягдлыг цуглуулах хогийн цэг байгуулах | 700,000 | 5 сард | | Хогийг түр цуглуулах савыг Газрын хөрснөөс дээш 80см зайнд байхаар тооцож хөлтэй ,салхивчтай бороо уснаас хамгаалсан хогийг газарт унгахгүй шууд машинд ачихаар тохируулж 2 хаалгатай хийсэн.үүнд 500.000 төгрөг зарцуулсан |
| 3. | Үйл ажиллагаанаас үүсэх шингэн хаягдлыг Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулан шийдвэрлэх | Жуулчны баазын 00, душны эсрэг талд суурилуулах | 7тн ионгс стандартын дагуу байршуулна. | 9,500,000 | 6 сард | | Ариун цэврийн байгууламж бохир ус цуглуулах цооногын цементэн доторлогооны ханыг 30см зузаантай, мөн газрын гадаргаас дээш 20-30см өндөр цутгаж 7тн- ган ёмкосыг суурилуулсан үүнд 9.000.000 сая төгрөг зарцуулсан. |
| | Нийт зардал | 9,500,000 /мян.төг/ | | | | | |

## ТАВ. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

**Хүснэгт 5.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Байгаль орчны удирдлагын тогтолцооны гол зорилго нь төслөөс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан илрүүлж түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах ба хянахад чиглэсэн байх ба байгаль орчны бодлогыг тодорхойлох, төлөвлөх,

хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, удирдлагын дүн шинжилгээ хийх гэсэн таван үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд энэ нь байгаль орчны үзүүлэлтийг тасралтгүй сайжруулах ач холбогдолтой.

| | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Нийт зардал /төг.мөнгө/ | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо | Жуулчны баазын эргэн тойронд ариутгал халдваргүйжүүлэлт хийх | Жуулчны баазын бүх объектууд | 40м2*10,000=40,000 | 6 сард | MNS3298:1991 Хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага | Ариутгал халваргүйжүүлэлтийн гэрээг “Ган өрлөг” ХХК-тай шинчлэн байгуулж нийт 60м2 талбайд ариутгал хийлгэж 100 мян.төгрөгийг зарцуулсан. |
| 2 | Ундны усны тоолууржуулах | Тоолууржуулалтыг зориулалтын аж ахуйн нэгжээр тавиулах | Жуулчны баазын ус соруулдаг хоолойн дээр суурилуулах | 350,000/мян.төг/ | 6 сард | Усны тухай хууль | “Хөвсгөл Ус Суваг” ХХК-аар LNS-25 загварын усны тоолуурыг 350,000-өөр тооцож суурилуулсан. |
| 3 | Нийт зардал | 450,000/мян.төг/ | | | | | |

## ЗУРГАА. Тухайн жилийн БОМТ, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

**Хүснэгт 6.1 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

| № | БОМТ, БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах, оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан/ | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хөвсгөл аймгийн БОАЖГ, Маргад жуулчны бааз | БОМТ-ийн биелэлтийн тайланг цахмаар хргүүлэх | Тухайн жилийн БОМТ-ийг БОНХСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны А/618 тоот тушаалаын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу БОМТ-ий биелэлтийг боловсруулна. | Жил бүрийн 11 сарын 01 | 120.0*1 жил=120,0 | Маргад жуулчны баазын менежер | Хатгалын БОТХБТ, Хөвсгөл нуурын УТХГХЗ, Маргад жуулчны бааз |
| 2. | Хөвсгөл аймгийн ЗД-ын томилсон ажлын хэсэг | Газар дээр нь дүгнэнэ. | | Жил бүрийн 12 сард | 120.0*1 жил=120,0 | Маргад жуулчны баазын менежер | БОАЖЯ, www.eic.mn-цахимаар |

## ДОЛОО. Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлвлөгөө

**Хүснэгт 7.1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь 2023 он | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сар.... | Сар.... | Сар.... | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | ХАБЭА сургалтад жуулчны баазын менежерийг хамруулах | 650,000/мян.төг/ | 2023.02 сард | | | Маргад жуулчны баазын БО-ны ажилтан | УБ-хотод “OSHMI”-сургалтын төвд ХАБЭА-мэргэшүүлэх сургалтад сууж төгссөн. |
| 2. | Маргад жуулчны баазын 2 ажилтанг мэргэшүүлэх сургалтад суулгах. | Үйл ажиллагааны зардал | 2023.06 сард | | | Маргад жуулчны баазын менежер Б.Даваахүү | Жуулчны баазын ажилтан Г.Сэржмядаг, Э.Түвшинзаяа, Б.Даваахүү нарыг БОАЖЯ-аас зохион байгуулсан “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”хүрээнд Зочлох үйлчилгээнй чанар, хүртээмж, ажилтнуудын харилцаа,хандлагыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд сууж сертификат авсан. |
| 3. | Жуулчны баазын ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах | 250,000/мян.төг/ | 2023.05 сард | | | | Жуулчны баазын 5 ажилтанд аймгийн Нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. |
| 4. | Галын аюулаас урьдчилан сэргийлэх | 150,000 /мян.төг/ | 2023.04 сард | | | | Аймгийн ОБГ-аар галын аюулгүй байлын дүгнэлт гаргуулсан. |
| | Нийт | 1,050,000 / мян.төгрөг/ | | | | | |

## НАЙМ. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

**Хүснэгт 8.1 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Арга хэмжээний хэрэгжилт, биелэлт |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Түүх, соёлын өвийг хамгаалах | Манай “Маргад” жуулчны баазын төсөл хэрэгжиж буй 8816м3 талбайд түүх, соёлын биет өв байхгүй. Иймээс 2023 оны БОМТ-нд “Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах шаардлагагүй гэж үзсэн. Гэсэн хэдий ч бид Хөвсгөл нуур, Хөвсгөл аймгийн түүх, соёлын биет өв, байгалийн сайхнийг түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байгаа тул орон нутгийн соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Үүний хүрээнд аялагч, жуулчдад Хөвсгөл нуурынхаа мэдээллийг түгээн дэлгэрүүлж, хамгаалах талаар “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу ажилладаг. |

## ДҮГНЭЛТ

Бид 2023 онд жуулчны баазынхаа дэд бүтцийг сайжруулах зорилгоор 100квт-ын трансформатор суурилуулж, байнгын цахилгааны эх үүсвэртэй болсон. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг баримтлан өвлийн байшин 3-ийг барьсан. Барилга байгууламжуудын өнгө үзэмжийг сайжруулахад онцгой анхаарч зарим байшингийн дээврийг сольсон. Мөн ариун цэврийн байгууламжийг өргөтгөн, угаалгын газрыг байгуулж, ариун цэврийн байгууламжийг сайжруулж, 28м хоолойг шинээр ашиглалтад оруулсан.

Баазынхаа хашааг засаж сэлбэн, будаж, далай эрэг дагуух хамгаалалтын дүмбийг шинэчилэн сольж босгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Цагаан үүр, Хатгал, Алаг-Эрдэнэ, Мөрөн сумаас 5 оюутан, 5 иргэнийг хөдөлмөрийн түр гэрээгээр жуулчны баазын тохижилт болон үйлчилгээний ажилд авч, ажиллуулсан нь тэднийг түр ажлын байраар хангаж, амьдрал болон сургалтын төлбөрт дэмжлэг болсон.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, салбарын хяналт, Онцгой байдал газар, Хатгал тосгоны захирагчийн алба, Хөвсгөл нуурын УТХГХ захиргаанаас зохион байгуулсан сургалтуудад идэвхтэй оролцов. Мөн манай жуулчны бааз нь БОАЖЯ, Хөвсгөлийн БОАЖГ, Алаг-Эрдэнэ сум, Хөвсгөл нуурын УТХГ-ын хамгаалалтын захиргаанаас ирсэн шалгалтад амжилттай дүн үзүүлснийг тэмдэглэж байна. Манай жуулчны баазад дотоодын 500 гаруй гадаадын / БНХАУ, Солонгос, Америк, Тайвань/ 20 гаруй жуулчид ирсэн байна.

Манай бааз 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж ажиллаа. Үүнд:

- Цэвэр ус ашиглах дүгнэлтийг Аймгийн БОЖГ-аар 2023 оны 6-р сарын 02-ны өдрийн Хө БО.2023/10 гаргуулав. Цэвэр ус ашиглах гэрээ, Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-тай шинэчлэн байгуулж цэвэр ус ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр, УТХГ-т газар ашигласны төлбөрийг тус тус барагдуулж, татварын байцаагч, газрын даамалтай тооцоо нийлсэн болно.

- Орчны тохижилт, ус хөрс ургамлыг хамгаалахад анхаарч жуулчны үйл ажиллагаа эхлэх болон оргил ачааллын үед баазынхаа доторх, гаднах, далайн эрэг дагуух хог хаягдлыг 2 хоног тутам цэвэрлэж, баримтжуулан усны хамгаалалтын бүс, ил задгай гал түлэх, бие засах, майхан барьж буух, нуурын усанд машин болон хувцас хунар угаахыг хориглох, гал түймрийн аюулаас сэргийлэн, жуулчдад санамж зөвлөмж өгч, хариуцсан байгаль хамгаалагчтай хамтран ажиллаж аялагчдын оргил үед баазынхаа 2 ажилтныг эргүүлээр  ажиллуулсан болно.
- Хог хаягдлын менежментийг сайжруулахад онцгой анхаарч, Жуулчны баазаас гарч байгаа хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, савлаж төрөлжүүлэн / шил, лааз, ус ундааны хуванцар сав, аюултай хог хаягдал гэх мэтээр/ хоёрдогч түүхий эдийг цуглуулагч Мөрөн сумын иргэн Б.Ганчимэгт нийлүүлсэн нь үр дүнтэй ажил боллоо. Хог хаягдал цуглуулж тээвэрлэх гэрээг Хүн байгаль нөхөрлөлийн ахлагч Ж.Сайнбаяртай байгуулж ачуулан хог хаягдлыг хяналтын хуудсаар Бохир ус тээвэрлэх гэрээг Мөнх–Оргил транс ХХК-ийн Ч.Болдбаатартай байгуулж, мөн хяналтын хуудсаар баталгаажуулан бүртгүүлж хяналт тавин ажиллав.

Манай жуулчны бааз нь ариутгал халдваргүйжүүлэлтийг аймгийн “Ган өрлөг” ХХК-аар хийлгүүлэх гэрээ байгуулж ахуйн хортон шавж, мэрэгч устгалыг хийлгэж, бохир усны цооног, 00, хогийн цэг , ариун цэврийн байгууламжийнд 2023 оны 6-р сард ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн болно.

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтэд анхаарч, олон наст ургамлыг үрээр тарьж, Тэр бум мод тарих ажлын хүрээнд 60 ширхэг мод тарьсан.

Алаг Эрдэнэ сум, Хатгал тосгоны Захирагчийн алба, Хөвсгөл нуурын УТХГХ-ын Захиргаатай байнга хамтран ажиллаж сум орон нутгийн түүхт ой, баяр наадам, ахмадын байгууллага, төсвийн байгууллагуудад хандив тусламж үзүүлж ирсэн ба 2023 онд Хатгал тосгоны ахмадын аялал, идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, цагдаагийн тасаг, Онцгой байдлын албаны байр барих зэрэгт мөнгөн хандив өгсөн

Хатгал тосгоны Цагдаагийн тасаг, онцгой байдлын газрын удирдамж чиглэлийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гал түймрийн аюулаас сэргийлэх, байгалийг экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх орчныг бохирдуулахгүй байх талаар ажлуудыг хийсэн.

Баазад ирсэн жуулчид амрагчид болон тэдний машин унааг бүртгэлжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар санамж зөвлөмж өгч, аялагч жуулчдын дагаж мөрдөх дотоод журмыг танилцуулан, барилга байшин объектуудыг камержуулж, харуул хамгаалалтыг сайжруулснаар элдэв гэмт хэрэг зөрчил бүртгэгдээгүй болно.

**Санал:**

1.Хөвсгөл нуурын эргэн тойронд байгаа айл өрхүүдийг эко ариун цэврийн байгууламжтай болгоход анхаарах.

2. Хатгалаас Тойлогтын уулзвар хүртэл асфальтан замыг 2024 оны 6 сард хугацаанд нь ашиглалтад оруулах талаар аймаг орон нутгийн удирдлага, сонгогдсон улсын их хурлын гишүүд онцгой анхаарах хэрэгтэй байна.

3. Хатгалын постоор орсон жуулчид ямар жуулчны бааз, отоглох цэгүүдэд хэд хоног байрласныг бүртгэлжүүлж тэднээс бааз, отгуудын талаар асуумж авч санал сэтгэгдлийг сонсож байх нь чухал ач холбогдолтой гэж бодож байна.

## Маргад жуулчны баазын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хавсралтууд

/ Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/



Бохир ус тээвэрлэлтийн гэрээ

2023 оны 07 сарын 03 ны өдөр Улаанбаатар хот

Нэг талаас Чулуунбаатар овогтой Болдбаатар "Мөнх-оргил транс" ХХК –ийг төлөөлж /цаашид Гүйцэтгэгч тал гэнэ/ нөгөө талаас ......../байгууллагыг/ төлөөлж тус байгууллагын ........
/албан тушаал/ /овог, нэр/
/цаашид Захиалагч тал гэнэ/ нар харилцан тохиролцож ......../байршил/ бохир ус тээвэрлэн зайлуулахаар 20.. оны .. сарын .. ны өдөр хүртэл гэрээ байгуулав.

Нэг. Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, эрх

1.1 Энэхүү байгуулсан гэрээний дагуу бохир усыг HD -170 маркийн 64-14 УНБ улсын дугаартай автомашинаар соруулж, тээвэрлэх үүрэг хүлээх
1.2 Гүйцэтгэгч нь захиалагчийн захиалгын дагуу товлосон хугацаанд ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.
1.3 Бензин, шатах тослох материалын болон инфляцийн өөрчлөлтийн улмаас тээвэрлэлтийн үнэд өөрчлөлт оруулах эрхтэй.

Хоёр. Захиалагч байгууллагын хүлээх үүрэг, эрх

2.1 Бохир ус соруулах машин багтахаар зам талбайг чөлөөтэй байлгах
2.2 Захиалагч гэрээний дагуу ажлын хөлсөө хугацаанд нь шуурхай төлөх
2.3 Захиалгаа нэг хоногийн өмнө урьдчилан өгөх

Гурав. Төлбөр тооцоо

3.1 Бохир усны нэг удаагийн тээвэрлэлтийн хөлсийг ........ төгрөг байхаар тохиролцов. /бичгээр/
3.2 Тээвэрлэлтийн хөлсийг ажил үйлчилгээ дуусмагц бэлнээр /дансаар/ төлөхөөр тохиролцов.
3.3 Шатахууны үнэ нэмэгдэхэд ажил үйлчилгээний үнийг нэмж тооцохоор тохиролцов.

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:
"Мөнх-оргил транс" ХХК-ийн захирал
........ Ч.Болдбаатар
/гарын үсэг/

Захиалагч талыг төлөөлж:
........
/албан тушаал, овог нэр/

/Бохир ус тээвэрлэх гэрээ/



ХАТУУ, ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3, Иргэний тухай хуулийн 476 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 169-р тогтоолын 17-р зүйлийг үндэслэн ________ /иргэн, аж ахуйн/ орчныг хог хаягдалгүй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор нэг талаас, ________ /тээвэрлэгч, албан тушаал/ нөгөө талаас ________ /захиалагч тал/ нар хамтран тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Гэрээний зорилго**

Захиалагч талын аялал жуулчлалын баазын хог хаягдал, бохирыг цэвэрлэж тээвэрлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

**Нэг. "Гүйцэтгэгч" ________ хүлээх үүрэг.**

1. "Хатгал нэвтрэх цэг"-т төвлөрсөн хог хаягдлыг тухай бүр нь Харганын нэгдсэн цэгт тээвэрлэх
2. ________ -ын хог хаягдал, болон ээнгүй хог хаягдлыг шаардлагатай үед ачиж нэгдсэн цэгт хүргэх
3. ________ шингэн бохирыг ачих ажлын хөлсийг ________ төгрөгөөр, Хатгал нэвтрэх цэгийн хог ачилтыг нэгудаагийн ачилтын зардлыг ________ төгрөгөөр тооцож ачиж тээвэрлэх
4. Хог хаягдлыг өөрийн унаагаар тээвэрлэж гэмтэл, засвар, үйлчилгээ, сэлбэг хэрэгслийг хариуцах
5. Ажлын төлөвлөгөө болон хуваарь, ажлын тайланг хамгаалалтын захиргаанд тайлагнах, тээвэрлэлт бүрт хяналтын хуудсаар бүртгэл хийлгэх
6. Тээвэрлэлтийн шатахууныг шаардах хуудсаар авч, тайланд тусгах

**Хоёр. Захиалагч талын хүлээх үүрэг.**

1. Хатуу, шингэн хог хаягдлын нэг удаагийн ачилтын ажлын хөлс ________ /хатуу, ________ шингэн / төгрөгийг тооцож олгох

**Гурав. Хамтран хүлээх хариуцлага**

1. Энэхүү гэрээг талууд 2023 оны 06 дугаар сарын 15-ээс 08 дугаар сарын 25 хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.
2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд хамтран хэлэлцэж гэрээг цуцална.
3. Гэрээний талуудад маргаан үүссэн тохиолдолд хамтран шийдвэрлэнэ.
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Батлав.
Гүйцэтгэгч тал:
2023 оны 7-р сарын 8

Батлав.
Захиалагч тал:
2023 оны 7-р сарын 8

/Хог хаягдал тээвэрлэх гэрээ/

/Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/



/Мод тарьж буй байдал/



/Мод тарьж буй байдал/

/Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/



Маргад гэр буудал
хог хаягдал, бохир тээвэрлэх
ХЯНАЛТЫН ХУУДАС

**/Хог хаягдал тээвэрлэх хяналтын хуудас/**



Маргад гэр буудал
хог хаягдал, бохир тээвэрлэх
ХЯНАЛТЫН ХУУДАС

**/Бохир ус тээвэрлэх хяналтын хуудас/**

**/Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/**

**/Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/**



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ 00225411





/Цэвэр усны тоолуур суурилуулсан байдал/

/Тоолуурын гэрчилгээ/



Татварын ерөнхий газар
2023-07-08 10:33:56

вcovгол аймгийн Алаг-
рдэнэ сумын засаг
аргын тамгын газар — 73224₮
эрэгэ шимтгэл — 600₮
ийт дүн — 73.824₮

атвар төлөгчийн регистр: ра97012017
Нэхэмжлэлийн дугаарууд:
вcгол аймгийн Алаг-
рдэнэ сумын засаг
аргын тамгын газар — 2230701568455

НӨАТ-ын баримт:
Сугалаа: ЕХ 47752205
Үнийн дүн: 600₮

ДДТД:
000006235972006230708126114407345
Энэхүү баримт нь НӨАТ-ын хуулийн дагуу
72 цагт баталгаажихыг анхаарна уу.

TermID:30001957
MerchID:GEREGE
Approval:5M7254
RRN:000958370417
DATE:2023-07-08T10:34:16
AMOUNT/MNT:73824.0₮

TDB

Гэрэгэ Системс ХХК
Утас: 77775773 Веб: www.gerege.mn

Баримтын дугаар
102223070810335669287

/Цэвэр ус ашигласны төлбөрийн баримт/



Татварын ерөнхий газар
2023-07-08 10:30:33

Газрын төлбөр-Дэд алба — 264480₮
Гэрэгэ шимтгэл — 600₮
Нийт дүн — 265.080₮

Татвар төлөгчийн регистр: ра97012017
Нэхэмжлэлийн дугаарууд:
Газрын төлбөр-Дэд алба — 1230405352677

НӨАТ-ын баримт:
Сугалаа: GS 35883221
Үнийн дүн: 600₮

ДДТД:
000006235972003230708126108407338
Энэхүү баримт нь НӨАТ-ын хуулийн дагуу
72 цагт баталгаажихыг анхаарна уу.

TermID:30001957
MerchID:GEREGE
Approval:48M154
RRN:000958368175
DATE:2023-07-08T10:32:47
AMOUNT/MNT:265080.0₮

TDB

Гэрэгэ Системс ХХК
Утас: 77775773 Веб: www.gerege.mn

Баримтын дугаар
102223070810303369283

/Газрын төлбөрийн баримт/

| | |
|---|---|
| <br>/Ариун цэврийн байгууламж суурилуулж буй байдал/ | <br>/7тн-ий ионгсийг суурилуулах бетон цутгаж буй хэсэг/ |
| <br>/Гэрээний дагуу бохир усаа соруулуулж буй байдал/ | <br>/Маргад жуулчны баазын арун цэврийн хэсэг/ |



/Ариун цэврийн өрөө, угаалтуурын хэсэг/



/Эмэгтэй ариун цэврийн өрөө/

**/Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд хийсэн ажлыг баталгаажуулах зураг/**



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ ADB ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

СЕРТИФИКАТ

Эрхэм хүндэт танаа

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Зочлох үйлчилгээний чанар, хүртээмж, ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд хамрагдсан тул сертификат олгов.

Сургалтын агуулга:

- Зочлох үйлчилгээний салбарт ажиллагсдын харилцаа, хандлага
- Зочлох үйлчилгээний салбарын менежмент

ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ П.ТУВШИНЖАРГАЛ

МӨНХ ХАРИЛЦАА ТББ ТЭРГҮҮН Э. ЦЭРЭНБАТ

2023.06.13

Ажилчдын сургалтад хамрагдсан сертификат



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ ADB ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

СЕРТИФИКАТ

Эрхэм хүндэт танаа

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Зочлох үйлчилгээний чанар, хүртээмж, ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд хамрагдсан тул сертификат олгов.

Сургалтын агуулга:

- Зочлох үйлчилгээний салбарт ажиллагсдын харилцаа, хандлага
- Жуулчны бааз, гэр буудлын үйл ажиллагааны дотоод стандарт
- Цэвэрлэгээ үйлчилгээний албаны ХАБЭА, журам, зааварчилгаа

ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ П.ТУВШИНЖАРГАЛ

МӨНХ ХАРИЛЦАА ТББ ТЭРГҮҮН Э. ЦЭРЭНБАТ

2023.06.13

Ажилчдын сургалтад хамрагдсан сертификат


OSHAcademy
Occupational Safety & Health Training
Certificate of Completion
Professional Development Program
This is to certify that
DAVAAKHUU BATAA
Has demonstrated academic excellence with distinction by completing all academic requirements in this 41-hour OSHAcademy Professional Development Certificate Program presented by OSHAcademy Authorized Training Provider (ATP), Occupational Safety and Health Management Institute of Mongolia (OSHMI). This achievement demonstrates commitment and professionalism in the field of Occupational Safety and Health.
OSH Specialist
Level 1
177951-130 Student #
01-25-2022 Issue Date
Steven J. Geigle, MA, CET, CSHM-E
Director, Instructor
OSHAcademy Safety and Health Training
Certificates can be validated through the OSHAcademy website.
www.oshacademy-atp.com/verify
VERIFIED TRAINING
BATBAATAR Dashzeveg, MSc, GradIOSH, CDWS
Director, Occupational Safety and Health Management Institute of Mongolia (OSHMI)
Ulaanbaatar, Mongolia
ATP #: 20120623DB
The content of this training conforms with U.S Department of Labor (OSHA) training standards and ANSI Z490.1, Criteria for Accepted Practices in Safety, Health and Environmental Training.

Ажилчдын сургалтад хамрагдсан сертификат


АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ
Дугаар 2104980
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:
Хаяг:
Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:
Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ ихэн шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байршуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Үндэсний тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7/
Олгосон: 2023 он 04 сар 13 өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 он 04 сар 13 өдөр хүртэл
Дүгнэлт олгосон:
аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга цолтой
Дүгнэлт гаргасан:
аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: цолтой
/тэмдэг дарна/

Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт